



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 17

Мөрөн

**“Шинэ Мөрөн худалдааны төв” ХК-ийн  
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2018 оны зардал батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.5 дахь заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Шинэ Мөрөн худалдааны төв” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны зардлыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан зардлыг үр ашигтай зарцуулж, гүйцэтгэл үр дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга даалгасугай.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зардлын зарцуулалт, үр ашигт хяналт тавьж ажиллахыг Цалин урамшууллын хороо, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Болд/ нарт даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

010029

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018  
оны 02 дугаар сарын 05 -ны өдрийн  
17 дугаар тогтоолын хавсралт

“Шинэ Мөрөн Худалдааны төв”  
ОНӨХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн  
2018 оны зардлын төсөв

Д/д	Зардлын төсөв	Сард	Нийт зардал
1	ТУЗ-ийн дарга, гишүүд -9	130,000	14,040,000
	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга-1	200,000	2,400,000
	<b>ТУЗ-ийн цалингийн зардал</b>		<b>16,440,000</b>
2	НДШ		2,055,000
4	Бичиг хэргийн зардал		492,000
5	Хурлын зардал		2,438,040
	<b>ДҮН</b>		<b>21,425,040</b>